



БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН ЯАМ



## “ИНЖЕНЕР ТЕХНОЛОГИЙН ДЭЭД БОЛОВСРОЛ” ТӨСӨЛ

01

### АГУУЛГА

Өндөр ур чадвартай,  
чадварлаг инженер,  
техникийн ажилтнуудыг  
бэлтгэх

Инженерийн боловсролын  
чанарыг нэмэгдүүлэхийн тулд  
багшлах боловсон хүчнийг  
бэхжүүлэх

Монголын инженерийн  
салбарын сургалтын орчинг  
сайжруулах

02

### ЗОРИЛГО

Монгол улсын инженерийн  
салбарт шаардлагатай  
инженерийн хүний нөөцийг  
бэлтгэх, судалгаа,  
боловсролын чадавхийг  
сайжруулах, бэхжүүлэх;

Монгол улсын аж үйлдвэрийн  
салбарын бүх бүрэлдэхүүн  
хэсгүүдэд чадварлаг хүний  
нөөцийг бэлтгэх;

ШУТИС болон МУИС-дад  
инженер бэлтгэх болон  
байгалийн ухааны  
хөтөлбөрүүдийг олон улсын  
түвшинд хүргэх

03

### ХҮЛЭЭГДЭХ ҮР ДҮН

Монголын үйлдвэрлэлийн  
инженер техникийн болон  
боловсон хүчний тоо  
нэмэгдэнэ

ШУТИС, МУИС-ийн инженер,  
технологийн чиглэлийн  
эрдэмтэн, багш, судлаачдын  
мэдлэг, заах арга зүй, чанар  
сайжирна

Судалгааны лаборатори,  
тоног төхөөрөмжийн чадавхи  
сайжирна, инженер болон  
байгаль орчны сургулт,  
судалгааны мэдлэг, ур чадвар  
дээшилнэ

### Төслийн үр дүн, ач холбогдол:

Төслийн хүрээнд бакалаврын сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн хамтарсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх, аж үйлдвэрийн салбарын эрэлтэд нийцсэн практик чадвар бүхий инженер, технологийн мэргэжилтэнг дотооддоо бэлтгэх, Японы их, дээд сургуулийн магистр, докторын зэргийн болон зэргийн бус сургалтуудад багш нарыг сургах, дотоодын их сургуулиудын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах, хоёр орны их сургуулиудын хооронд хамтарсан судалгааг хэрэгжүүлэх зэргээр Монгол Улсын аж үйлдвэрийн салбарт тулгараад буй инженер, технологийн хүний нөөцийн дутагдлыг бууруулж, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах ихээхэн ач холбогдолтой бөгөөд дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн чанартай боловсролыг олгох юм.

Япон улсад 2014-2024 он хүртэл нийт 1000 гаруй оюутан багш, судлаачид хамрагдах ба инженер, технологи болон байгалийн ухааны чиглэлээр Коосэн, хамтарсан бакалавр,

магистр, доктор, зэргийн бус хөтөлбөрт суралцана. Суралцах хугацаанд нь зээл /сургалтын төлбөр, амьжиргааны зардал, замын зардал/ олгоно. Суралцагч сургалтын хөтөлбөрүүдэд амжилттай суралцаж, төгсөж ирээд Монгол улсад 5 жил тогтвортой, үр бүтээлтэй ажилласан тохиолдолд энэхүү зээл нь тэтгэлэг болох нөхцөлтэй юм.

Төслийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.mjeed.edu.mn> сайтаас авна уу.

### ШУТИС-ИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХҮРЭЭНД “ИТДБ”-ТӨСЛИЙН ХАМТАРСАН СУДАЛГААНЫ 10 БАГ

№	Тэргүүлэх чиглэл	№	Хамтарсан судалгааны сэдэв	Судалгааны багийн ахлагч	Хамтран ажиллаж буй Япон улсын их, дээд сургууль
I	ШИНЭ МАТЕРИАЛ, НӨӨЦИЙН ТЕХНОЛОГИЙН ИНЖЕНЕРЧЛЭЛ	1	МОНГОЛ ОРНЫ ЭРДЭС БАЯЛАГИЙН СУУРЬ СУДАЛГАА	С.ЖАРГАЛАН	КЮУШУ ИС, АКИТА ИС, ТОХОКУ ИС, НИЙГАТА ИС, ХОККАЙДО ИС
		2	ҮНСИЙГ БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛД АШИГЛАХ НОГООН ТЕХНОЛОГИ	Д.СҮНЖИДМАА	ТОХОКУ ИС, НИХОН ИС
		3	ШИНЭ МАТЕРИАЛЫН ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИЙН СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТ	М.ДЭЛГЭРМАА	НИЙГАТА ТИС, НИЙГАТА ИС, ҮЦУНОМИЯА ИС, АКИТА ИС
II	ЭРЧИМ ХҮЧ БАЙГАЛЬ ОРЧНЫ ИНЖЕНЕРЧЛЭЛ	4	МОНГОЛЫН ТЭНГЭРИЙН ДЭД БҮТЭЦ: АЭРО ХӨДӨЛГҮҮР, БАЙГАЛЬ ОРЧИНЫ МОНИТОРИНГ, МЕХАНИК БОЛОН ТЭЭВРИЙН ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ШУ, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИ БА БОЛОВСРОЛ	Б.ЭРДЭНЭБАТ	НАГАОКА ТИС, КЮУШУ ИС
		5	ХҮРЭЭЛЭГЧ ОРЧНЫ БОХИРДЛЫН ХЯНАЛТЫН ЦОГЦОЛБОР СУДАЛГАА, ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: ТӨВ МОНГОЛЫН ТУУЛ, ХАРАА ГОЛЫН АЙ САВУУДЫН ЖИШЭЭН ДЭЭР	О.МӨНХЦЭЦЭГ	НАГОЯА ИС, ТОХОКУ ИС
		6	ЭРЧИМ ХҮЧНИЙ ДАМЖУУЛАЛТ ТҮГЭЭЛТИЙН ИННОВАЦИЙН СУДАЛГАА	Б.СЭРГЭЛЭН	ТОКИО ИС, ДОШИША ИС, АШИКАГА ИС, КЮУШУ ИС, КУМАМОТО ТИС, РЮУКУ ИС
		7	МОНГОЛ ОРНЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СУДАЛГАА	Ц.ЦОГГЭРЭЛ	ТОХОКУ ИС, ЧИБА ИС, МИАКОНОЖО КОЛЛЕЖ, КИТАКЮУШУ ИС
III	АВТОМАТЖУУЛАЛТ, СИСТЕМИЙН ИНЖЕНЕРЧЛЭЛ	8	АВТОМАТЖУУЛАЛТ, СИСТЕМИЙН ИНЖЕНЕРЧЛЭЛ	Г.ХИШИГЖАРГАЛ	ТОКУШИМА ИС, КИОТО ТИС
IV	БИО ИНЖИНИРИНГ (хүнс, эм бэлдмэл, биопринтинг)	9	МОНГОЛЫН ХҮНСНИЙ ЗАРИМ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХАТААХ АРГЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА	Ц.ОДБАЯР	ХОККАЙДО ИС, ЦУКУБА ИС
		10	ХҮНИЙ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ БИО-ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТ	Д.ГАНБАТ	ХОККАЙДО ИС, ЦУКУБА ИС, КИОТО ТИС